

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар  
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүйн сайдын 2015 оны А/188 тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах журам”-д дор дурдсан агуулгатай 1.5 дахь хэсэг, 6.1.4 дэх заалт тус тус нэмсүгэй.

1/Нэгдүгээр зүйл:

“1.5.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд /цаашид “Зөрчил гаргагч” гэх/-д Засгийн газрын 2017 оны 194 дүгээр тогтоолоор баталсан “Шийтгэлийн хуудасны маягт”-ын дагуу торгох шийтгэл оногдуулна.”,

2/Зургаадугаар зүйл:

“6.1.4.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 6-д заасны дагуу харилцаа холбооны хэрэгсэл ашиглан хүргүүлсэн шийтгэлийн болон торгуулийн мэдэгдэх хуудсыг зөрчил гаргагч хүлээн аваагүйгээс хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол.”

2.Мөн журмын 2.2.1, 2.2.3, 2.3.3, 2.3.5 дахь заалтыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай.

1/2.2 дахь хэсэгт:

“2.2.1.стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр зөрчил үйлдснийг баримтжуулсан тохиолдолд шийтгэлийн хуудсыг маягт /Торгуулийн мэдэгдэх хуудас/-ын хамт харилцаа холбооны хэрэгсэл ашиглан зөрчил гаргагчийн хаягаар хүргүүлэх;

2.2.3.шалгах төхөөрөмж, стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмж байхгүй үед нотлох баримтыг үндэслэн шийтгэлийн хуудас бичиж, торгуулийг холбогдох дансанд тушаалгана.

2.3.3.зөрчил үйлдснийг баримтжуулсан зураг;

2.3.5.зөрчил үйлдсэн хүний тээврийн хэрэгслийн зураг;”.

3.Мөн журмын 1.1 дэх хэсгийн “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн зөрчлийг хянан шийдвэрлэх,” гэснийг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчлийг шалган шийдвэрлэхэд” гэж, 2.2.2 дахь заалтын “шийтгэврийг” гэснийг “торгох шийтгэлийн хуудсыг” гэж, 3.3 дахь хэсгийн “гаргасан этгээд” гэснийг “үйлдсэн хүн, хуулийн этгээд” гэж, 4.4 дэх хэсгийн

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын” гэснийг “Зөрчлийн” гэж, 6.1.2 дахь заалтын “захиргааны хариуцлагаас” гэснийг “шийтгэлээс” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Мөн журмын 2.3 дахь хэсгийн “өнгөтөөр”, 2.3.1 дэх заалтын “/бар код/” гэснийг, 2.3.7 дахь заалтыг тус тус хассугай.

5.“Торгуулийн мэдэгдэх хуудас”-ыг хавсралтаар баталсугай.

6.Хууль зүйн сайдын 2015 оны А/188 тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Зөрчилд ногдуулсан торгуулийн мэдэгдэх хуудас”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

7.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа С.Баатаржав/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/ нарт тус тус даалгасугай.

8.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТОРГУУЛИЙН МЭДЭГДЭХ ХУУДАС

Бүртгэлийн дугаар:  
Шийтгэл оногдуулсан огноо:



ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тээврийн хэрэгсэл эзэмшигч /өмчлөгч/-ийн мэдээлэл, гаргасан зөрчил		/тээврийн хэрэгслийн зураг/
Овог нэр		
Хуулийн этгээдийн нэр		
Регистрийн дугаар		
Зөрчил гаргасан огноо		
Цаг минут		
Байршил		
Тээврийн хэрэгслийн өнгө, марк, улсын дугаар		
Гаргасан зөрчил		
Зөрчлийн тухай хуулийн зүйл, заалт		
Холбоо барих		

ЗӨВЛӨМЖ:

- 1.Оногдуулсан шийтгэлийг энэхүү мэдэгдэх хуудсыг хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор Төрийн сангийн..... тоот дансанд тушаана.
- 2.Дээр заасан хугацаанд оногдуулсан шийтгэлийг сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гүйцэтгүүлнэ.
- 3.Шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлд заасны дагуу прокурорт бичгээр гомдол гаргах эрхтэй болно.
- 4.Холбогдох мэдээлэл авах утасны дугаар ..... цахим хуудасны хаяг